



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/649

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулж,  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 4.1, аймгийн Шуурхай штабын 2023 оны 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилт хүндэрч их хэмжээний цас орсонтой холбогдуулан Цэцэрлэг, Цагаан-уул сумдад зудын эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг нэгдүгээр, Улаан-Уул суманд зудын эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, зудын эрсдэлийн үнэлгээг хийж хэрэгжилтийг аймгийн Шуурхай штабт 2023 оны 12 дугаар сарын 25 ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Эрсдэлийн үнэлгээ хийх үйл ажиллагаанд шаардлагатай 5,320,000 (Таван сая гурван зуун хорин мянган) төгрөгийн шатахуун, томилолтын зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.


ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР



Аймгийн Засаг даргын 2023 оны  
12 дугаар сарын 19-ны өдрийн 12/12 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ, ЦАГААН-УУЛ СУМДАД  
ЗУДЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН  
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Л.Эрхэмбаяр-(Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)

Гишүүдэд:

С.Ганболд - (Онцгой байдлын газрын төлөвлөлт, бэлтгэл бэлэн  
байдал хариуцсан ахлах мэргэжилтэн хошууч)


М.Даваамөнх - (Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн)

Э.Амаржаргал – (Ус цаг уур орчны шинжилгээний төвийн ахлах  
техникч )

Б.Батдорж -(Хүнс хөдөө аж ахуйн газрын жолооч)



Аймгийн Засаг даргын 2023 оны  
12 дугаар сарын 12-ны өдрийн 16 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт



УЛААН-УУЛ СУМАНД ЗУДЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ  
ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Л. Бямбасүрэн-(Онцгой байдлын газрын гамшгаас  
хамгаалах улсын ахлах байцаагч, хошууч)

Гишүүдэд:

Э.Баяржаргал - (Ус цаг уур орчны шинжилгээний төвийн цаг уур  
орчны технологийн хэлтсийн дарга )

Н.Билэгдэмбэрэл-(Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Т.Хөвсгөл-(Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн  
төвийн мэргэжилтэн)



Уймгийн Засаг даргын 2020 оны 12-ны өдрийн 3 дугаар хавч

## ЗАРДЛЫН ТООЦОО

[illegible]